

ШИВЭЭГОВЬ СУМЫН ЦАГ ҮЕИЙН МЭДЭЭ

/2018.10.25 - 2018.11.23/

УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТ


Сумын эдийн засаг, нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн төслийг боловсруулан 2018 оны 10-р сарын 18-ны өдрийн 2/808 тоот албан бичгээр сумын ИТХ-д хүргүүлсэн.

Говьсүмбэр аймгийн ГБХЗХДГ-аас зохион байгуулсан Хамтарсан багийн өдөрлөгт оролцож сумын “Хамтарсан баг”-ийн 2018 онд хийж гүйцэтгэсэн ажлаараа аймагт 2-р байранд шалгарч Өргөмжлөл, мөнгөн шагналаар шагнагдсан.




Сумын “Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг дэмжих” дэд хөтөлбөрийн хүрээнд “Ахмадын дуун цэнгүүн”-ийг 2018 оны 11 сарын 12-ны өдөр хамтлаг, гоцлол дууны төрлөөр зохион байгуулж 50 гаруй ахмад настан хамрагдаж, шилдгүүдээ шалгарууллаа.

Засгийн газрын 2018 оны 258 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх төлөвлөгөөний дагуу сумын Засаг даргын Тамгын газрын 2 давхарт 2 камер суурилуулан хяналт тавин ажиллаж байна.



Сумын албан байгууллагуудын хаягийг Монгол хэл болон Монгол бичгээр хослуулан бичиж байрлуулах ажлыг зохион байгууллаа. Сумын Соёлын төв, Ерөнхий боловсролын сургууль хаягаа шинэчилж байршуулж, бусад байгууллагууд хэвлэлийн компанид захиалгаа өгөөд байна.



Сумын төвийн төвлөрсөн хогийн цэгт шинээр 336 м3 нүх ухаж, дүүрсэн нүхийг булах төвлөрсөн хогийн цэгийг цэвэрлэх ажлуудыг 11 сарын 08-ны өдөр зохион байгуулж ажилласан.



ЭДИЙН ЗАСАГ, ТӨСӨВ САНХҮҮ

2018 оны 11-р сарын 23-ны байдлаар орон нутгийн төсөвт байгууллагуудын санхүүжилт болон зардлын гүйцэтгэл өссөн дүнгээр дараах байдалтай байна.

№	Байгууллагын нэр	Санхүүжилт /мянган.төг/	Зардлын гүйцэтгэл /мянган.төг/
1.	ИТХ	39196500	38840179
2.	ЗДТГ	263280700	257710700

Төвлөрсөн төсөвт байгууллагуудын санхүүжилт болон зардлын гүйцэтгэл дараах байдалтай байна.

№	Байгууллагын нэр	Санхүүжилт /мянган.төг/	Зардлын гүйцэтгэл /мянган.төг/
1.	Эрүүл мэндийн төв	300400800	276879557
2.	Соёлын төв	52100000	51747855
3.	3-р сургууль	711242300	707721217
4.	3-р цэцэрлэг	362371000	358806759

ХУУЛЬ ЭРХ ЗҮЙ

Аймгийн эдийн засаг, нийгмийг 2018 онд хөгжүүлэх үндсэн чиглэлээс 23 зорилтын хүрээнд 41 арга хэмжээг хяналтанд авч жилийн эцсийн байдлаар 94,1 хувийн гүйцэтгэлтэй хэрэгжүүлэн ажилласан. Жилийн эцсийн биелэлтийг 2018 оны 11-р сарын 07-ны өдрийн 1/851 тоот албан бичгээр ТЗУХ-т хүргүүлсэн.

Аймгийн Засаг даргын 2016-2020 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрөөс 23 зорилтын хүрээнд 47 арга хэмжээг хяналтанд авч жилийн эцсийн байдлаар 89 хувийн гүйцэтгэлтэй хэрэгжүүлэн ажилласан. Жилийн эцсийн биелэлтийг 2018 оны 11-р сарын 07-ны өдрийн 1/851 тоот албан бичгээр ТЗУХ-т хүргүүлсэн.

БОЛОВСРОЛ, СОЁЛ, ЭРҮҮЛ МЭНД, НИЙГМИЙН ХАМГААЛАЛ:

3-Р АХЛАХ СУРГУУЛЬ

Аймгийн Боловсрол, Соёл, Урлагийн газраас зохион байгуулсан математик, физикийн багш нарын дунд 2018 оны 10 дугаар сарын 22-ны өдөр зохион байгуулагдсан “Залуу багш нарын ур чадвар”-ын уралдаанд сумын ЕБСургуулийн физикийн багш Э.Долгормаа, математик мэдээлэлзүйн багш Ж.Баярцэцэг нар оролцож багш Ж.Баярцэцэг “Тэргүүн” байр, физикийн багш Э.Долгормаа дэд байрыг эзэлсэн амжилтыг үзүүлсэн байна.

Plickers – Маш богино хугацаанд суралцагчдын хариултыг цуглуулах программ юм. Суралцагчдад бар код бүхий карт тараан өгч ухаалаг гар утсаар бар кодын зургийг авах байдлаар мэдээлэл цуглуулж түүндээ анализ хийн, харьцуулан судалгаа хийх боломжийг олгодог. Энэхүү программуудыг ашигласанаар багш нарын ажлын цаг, ачааллыг багасгаж цаас хор хэрэглэхгүйгээр богино хугацаанд үр дүнг тооцож ажиллах боломжоор хангагдаж байна. Энэхүү программыг сургуулийн багш нарт түгээн дэлгэрүүлж, боловсролын салбарын болон багш нарт холбогдох хууль дүрэм, журмыг уншиж судлах ажлыг зохион байгуулж байна.

“School police” эцэг эхийн эргүүл өдөрт 1 ангиас 2 эцэг эх гарч хүүхдийг эрсдэл, ослоос сэргийлэх, туслах үйлчилгээ үзүүлж байна. 11-р сард нийт 48 эцэг эх эргүүлд гарсан.

Багш нарынхаа ажиллах орчинг сайжруулж таатай орчинг бүрдүүлэх, хууль эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх зорилгоор багш хөгжлийн төвийг хувийн хэвшил болон аж ахуйн нэгжтэй хамтран тохижуулах ажлыг зохион байгуулж багш хөгжлийн төвд шинээр заах аргын нэгдлүүдийн самбар болон хуулийн самбар болох 4 самбар хийж байршууллаа.

3-Р ЦЭЦЭРЛЭГ

Суманд хүүхэд харах үйлчилгээ явуулдаг 2 иргэн ар гэрийн шалтгаанаар чөлөө авсантай холбогдуулан 2018-2019 оны хичээлийн жилд 3-р цэцэрлэгийн салбар бүлгийг 21 дүгээр зөрлөг дээр байгуулж, сумын алслагдсан багийн хүүхдүүдийг сургуулийн өмнөх боловсролд хамруулж байна.

Сургуулийн өмнөх боловсролын “Цөм” хөтөлбөрийн хүрээнд Бага бүлэг - “Тээвэр” Дунд бүлэг - “Гэр бүл”, Ахлах бүлэг - “Дүрсний орноор аялацгаая” Бэлтгэл бүлэг - “Ном” сэдвээр төсөлт тоглоом, тоглонгоо суралцъя арга зүйгээр явуулж байна.

Цэцэрлэгийн бүх бүлгүүдийн эцэг, эхээс хэрэглэгчийн үнэлгээг авч дүгнэлт хийхэд 90% нь цэцэрлэгийн үйл ажиллагаанд маш сайн үнэлгээг өгсөн байна.

3-р цэцэрлэгийн багш нарын дунд Багшийн ёс зүйн дүрмийг судлан хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж багш нарын “Хуулийн зах”-ийг ажиллуулж байна. Мөн багш бүр тодорхой нэг хуулийг бие даан судлан бусад багш нартаа гарын авлага болон тараах материал хийж нэгдсэн хэлэлцүүлгийг 3 удаа зохион байгуулсан.



Сумын 3 дугаар цэцэрлэг өөрсдийн хөрөнгөөрөө гэр цэцэрлэгтээ үүдний амбаар барьсан.



ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВ

Эрүүл мэндийн төвд 22 өвчтөн хэвтэж үүнээс 10-н хүүхэд хэвтэн эмчлүүлж байна.

Эмнэлгийн үйлчилгээ нь:

- Амбулаторийн үзлэг – 273
- Урьдчилан сэргийлэх үзлэг – 129
- Дуудлага- 83

Цаг агаар хүйтэрч байгаатай холбоотой бага насны хүүхдийн томуугийн өвчлөл нэмэгдэх хандлагатай байна.



Сургуулийн дотуур байрны хүүхдүүдэд “Цагаан хорхойтох өвчнөөс урьдчилан сэргийлье” сэдэвт сургалтыг зохион байгуулсан.

Эмнэлэгт хэвтэн эмчлүүлсэн, хүүхдээ асарч байгаа ээжүүдэд “Томуугаас урьдчилан сэргийлэх цэгэн дасгал” сургалт тогтмол зохион байгуулж байна.



3-р цэцэрлэгийн 210 хүүхдийг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулж, витамин А олгосон.



Аймгийн нэгдсэн эмнэлгээс мэргэжлийн эмч урьж ЕБС-ийн 14-17 насны 60 охидыг үзлэгт хамруулан, “Охидын бэлгийн ариун цэвэр” сэдэвт сургалтыг зохион байгуулсан.



Хөгжлийн бэрхшээлтэй байнгын асаргаа шаардлагатай 0-5 насны 30 хүүхдийг нарийн мэргэжлийн эмчийн үзлэгт хамруулан витаминжуулах ажлыг зохион байгуулсан.

“Элэг бүтэн Монгол-2” илрүүлэг шинжилгээнд 2018 оны 11 сарын байдлаар нийт 1055 иргэн хамрагдаж, хөтөлбөрийн хэрэгжилт 74%-тай байна.

“Цус эрүүл бол бие эрүүл” аяны үйл ажиллагаанд нийт 1226 хүн хамрагдаж 65,5 %-тай хамрагдаж байна.

УЛСЫН БҮРТГЭЛ

Иргэний бүртгэлийн үйлчилгээг 87 иргэнд үзүүлсэн ба үүнээс шинэчилсэн бүртгэлд 5 иргэн бүртгэж баримтыг аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн Иргэний бүртгэлийн тасагт хүлээлгэн өгч экспорт хийгээд байна.

11-р сард газраа анх удаа өмчилж авч байгаа 58 иргэний материалыг хүлээн авч газар өмчлөлийн гэрчилгээг олгоод байна. Эхний 11 сарын өссөн дүнгээр 108 иргэн газар өмчлөлийн гэрчилгээг хүлээн аваад байна.

Иргэдээс 11 сард 57 өргөдөл хүлээн авсныг хугацаанд нь шийдвэрлэсэн. Өргөдлийн тоо өссөн нь уурхайн байр хувьчлагдаж байгаатай холбогдуулан баг дотор шилжилт хөдөлгөөний бүртгэлийг өссөн дүнгээр нийт 299 иргэн хийлгэсэн байна. Мөн өөр аймгаас манай суманд шилжин ирсэн иргэдийн тоо нэмэгдсэн үзүүлэлттэй байна.

Иргэний гэр бүл байдлын статистик мэдээ тайлан болон Иргэний бүртгэлийн чиглэлээр хийж гүйцэтгэсэн ажлын тайлан, үнэт цаасны тайлан, үнэт цаасны орлогын тайлан зэргийг гаргаж холбогдох байгууллагуудад хүргүүлээд байна.

ХҮН АМЫН ЕРДИЙН ХӨДӨЛГӨӨНИЙ 2018 ОНЫ 11 САРЫН МЭДЭЭ

	м/д	Бүгд	Үүнээс:					
			Хот			Хөдөө		
			Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
Төрсөн хүүхэд	1	70				78	41	37
Төрсөн эх	2	70				78		78
Бүртгүүлсэн гэр бүл	3	21				23	23	23
Нас баралт	4	16				16	10	6
Цуцалсан гэр бүл	5	7				7	7	7
Үрчлэгдсэн хүүхэд	6	4				4	2	2
Аймаг, нийслэлээс шилжин ирсэн	7	134				134	65	69
Аймаг, нийслэл рүү шилжин явсан	8	84				84	43	41

ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН ШИВЭЭГОВЬ СУМЫН ИРГЭНИЙ БҮРТГЭЛИЙН ҮЙЛЧИЛГЭЭНЭЭС ОРСОН ОРЛОГО

2018.11.23

д/д	Үйлчилгээний нэр төрөл	2018 оны 11-р сар					Бүгд	Тайлбар
		Үйлчилгээний хураамж 300200022101 тоот дансанд		Бүгд	Тэмдэгтийн хураамж 300300123138 тоот дансанд			
		Нэг бүрийн үнэ	Тоо		Нэг бүрийн үнэ	Тоо		
1	Эцэг тогтоосны бүртгэл	2500	2	5000				
2	Гэрлэлтийн бүртгэл	2500	2	5000				
3	Сум доторх шилжилт	1500	16	24000	1000	16	16000	
4	Үрчлэлтийн бүртгэл	2500	1	2500				
5	Гэрлэлт цуцлалт	2500	1	2500				

6	Гэрлэлтийн гэрчилгээ дахин	5000	1	5000				
7	Өөр аймаг шилжин явсан	2500	2	5000	1000	2	2000	
8	Төрсний гэрчилгээ дахин	5000	1	5000				
Дүн		54000			18000			
д/д	Үйлчилгээний нэр төрөл	Үйлчилгээний хураамж 300200022130 тоот дансанд		Бүгд	Тэмдэгтийн хураамж 300300123138 тоот дансанд		Бүгд	Тайлбар
		Нэг бүрийн үнэ	Тоо		Нэг бүрийн үнэ	Тоо		
7	Иргэний үнэмлэх	15000	9	135000	3300	9	29700	
Дүн		135000			29700			
Нийлбэр дүн		189000			47700			
Нийт орлогын дүн		236700						

НИЙГМИЙН ХАЛАМЖ

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн “Ажлын байрыг дэмжих хөтөлбөр”-т суманд үйл ажиллагаа явуулдаг 2 оёдолчин хамрагдаж тус бүр 5 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэгийг аваад байна.



Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн хүрээнд “Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр”-т 2-р багийн иргэн Д.Эрдэнэхишигийн төсөл дэмжигдэж гэрээ байгуулан 2018 оны 10-р сарын 29-ний өдөр 4 сая төгрөгийн 40 толгой хонийг хүлээж авсан.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн “Хөдөлмөрт бэлтгэх хөтөлбөр”-ийн хүрээнд сумын ажилгүй хөдөлмөрийн насны 15 иргэнд “Гоо засал”-ын мэргэжил олгох сургалтыг Улаанбаатар хотын “АС” сургалтын төвтэй хамтран 2018 оны 10-р сарын 08-ны өдрөөс эхлэн 30 хоногийн хугацаанд зохион байгуулж дууссан.



Улаанбаатар хотын “Зөв амьдрах ухаан ТББ”-аас Шивээговь сумын 50 ахмад настанд Нийгмийн халамжийн тухай хуулийн Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээний “Өдрийн үйлчилгээ”-г 2018 оны 11-р сарын 12-оос 16-ны хооронд 5 хоногийн хугацаанд зохион байгуулсан.



НИЙГМИЙН БОДЛОГО



Сумын “Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг дэмжих” дэд хөтөлбөрийн хүрээнд намрын витаминжуулалтын ажлыг зохион байгуулж байнгын асаргаа шаардлагатай 19 иргэнийг хамрууллаа.

Сумын “Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг дэмжих” дэд хөтөлбөрийн хүрээнд “Ахмадын дуун цэнгүүн”-ийг 2018 оны 11 сарын 12-ны өдөр хамтлаг, гоцлол дууны төрлөөр зохион байгуулж 50 гаруй ахмад настан хамрагдаж, шилдгүүдээ шалгарууллаа.



БАЙГАЛЬ ОРЧИН

АБ, ААН айл өрхөөс хог хаягдал гаргасны төлбөрийг хураан авах ажлыг зохион байгуулж 11-р сарын байдлаар ОНО-ын хог хаягдлын хураамжид 9377400 төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Бүх нийтийн их цэвэрлэгээг 2018 оны 11 дүгээр сарын 07-нд зохион байгуулж 15 аж ахуйн нэгж байгууллагын 120 иргэн 3.5 га талбайн 4.5 м3 хог хаягдлыг түүж цэвэрлэн төвлөрсөн хогийн цэгт ачиж зайлуулсан.





“Илчлэг шивээ ОНӨҮГ-тай хамтран “Бэхтийн булаг”-ийн эхийг хашаажуулах ажлыг зохион байгуулсан.



Сумын Засаг даргын 2018 оны 11 сарын 06-ны өдрийн А/164 дугаар захирамжаар “Агаар бохирдуулагч эх үүсвэрийн нэгдсэн тооллог”-ын ажлыг 5 хүний бүрэлдэхүүнтэй 11 сарын 06-15-ны өдрүүдэд зохион байгуулж, галалгаатай гэр болон байшинд амьдардаг 192 айл өрх, 100квт хүртэл хүчин чадалтай зуух хэрэглэдэг 2 аж ахуй нэгж хамрагдсан байна.

Аймгийн засаг даргын 2018 оны А/314 дугаар захирамжийн дагуу хууль бус ан агнуур, малын хулгайн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор Шивээговь сумын 2-р багийн нутаг дэвсгэр, бэхт, бөгсийн ар, тогоо булаг, 8-н шороот гэсэн газруудаар нийт 120 км-р эргүүл, хяналт шалгалтын ажлыг зохион байгуулж ажилласан. Эргүүл шалгалтын хугацаанд “Цагаан зээр”-ийн нутагшил, өвс Ургамлын гарц, отор нүүдэл зэрэгт тандалт хийсэн. Мөн 2-р багийн малчин 15 айл өрхөд хууль бус ан агнуураас урьдчилан сэргийлэх талаар яриа, танилцуулга, зөвөлгөө өгч ажиллаа.



ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САН

Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэх Өвсний нэгдсэн фондыг нэмэгдүүлэх ажлыг иргэн Т.Батнасантай 5.2 сая төгрөгийн гэрээ байгуулж, 798 боодол өвс худалдан авсан.



Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэх “22 дугаар зөрлөгт иргэдийн чөлөөт цагийг өнгөрүүлэх талбай байгуулах” ажлын гүйцэтгэгтэй 2018 оны 10 дугаар сарын 24-ний өдөр сонсох ажиллагаа зохион байгуулж, гэрээг цуцалсан.

Орон нутгийн хөгжлийн сангийн 2 сая төгрөгийн хөрөнгөөр 2018 онд хийгдсэн Нийтийн эзэмшлийн ногоон байгууламжийн усалгаа арчилгааны ажлын гүйцэтгэлийг 11-р сард хүлээн авсан.

МЭДЭЭГ НЭГТГЭСЭН:

НЗЭЗАХМ

О.БОЛОРМАА

ХЯНАСАН:

ЗДТГ-ЫН ДАРГА

Д.ОТГОНЖАРГАЛ